



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/66.

Хэрлэн сум

Дуудлагын худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2. 29.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 78 дугаар зүйлийн 78.2.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн өмчит Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын 7,657,304 төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжгүй хоёр давхар конторын зориулалттай модон барилгыг дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дотор хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Цэнхэрмандал сумын Засаг дарга /С.Золжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА